



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 1164

Хужирт сум

「Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажил
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8.1, 9.8.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны “Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” А/615 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, шүлхий өвчний яаралтай дархлаажуулалтад ажиллах хүн хүч, шатахуун, бусад холбогдох зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дархлаажуулалтын ажлыг товлосон хугацаанд үр дүнтэй, чанартай зохион байгуулж ажиллахыг ажлыг хэсэг (З.Цэцэгмаа), малчин, мал бүхий иргэдэд мэдээлж, малыг бүрэн хамруулахад анхаарч ажиллахыг багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Дархлаажуулалтад шаардагдах зардлыг малын тоо толгойн албан татварын зардлаас зарцуулахыг Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй

5. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хяналт тавьж ажиллан, үр дүнг Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа)-д даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДЭМБЭРЭЛ

622301329

D:Alban bichig:Zahiramj 2023